



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 4/461

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1.1. "Жи энд Пи Бойс трейд" ХХК /2665573/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2201017246 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, Энх тайваны өргөн чөлөө, 1502 тоот хаягт байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай эд хөрөнгийн 000193618 дугаартай;

1.2. "СэБоЦэ" ХХК /2100703/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2201030984 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Дааган толгой гудамж /18490/, ГХ-3 тоот хаягт байрлах, гүний худаг 000229019 дугаартай;

1.3. Иргэн Б.Баасандалай /РБ80022203/, Б.Шинэбаяр /УЦ11212177/, Б.Энхжин /РБ03242918/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2202001863 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо, Согоот 60 дугаар гудамж, 794 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 355273 дугаартай;

1.4. Иргэн Б.Баасандалай /РБ80022203/, Б.Шинэбаяр /УЦ11212177/, Б.Энхжин /РБ03242918/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2202010880 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо, Согоот 60 дугаар гудамж, 794 тоот хувийн сууцны 468683 дугаартай;

1.5. Иргэн Б.Нарангэрэл /ПГ82122024/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2202004574 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо, Яргайт 11 дүгээр гудамж, 168 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 364026 дугаартай;

1.6. Иргэн Б.Нарангэрэл /ПГ82122024/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2202007909 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо, Яргайт 11 дүгээр гудамж, 168 тоот хувийн сууцны 443654 дугаартай;

1.7. Иргэн Д.Пүрвээ /ХЗ39030717/, П.Эрдэнэзаяа /ХИ78123001/, Э.Ариунзаяа /УХ99031040/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2202007574 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо, Яргайт 40 дүгээр гудамж, 625 тоот хувийн сууцны 000092548 дугаартай;

1.8. Иргэн Ц.Нарангэрэл /КЮ80072861/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204027608 дугаарт бүртгэлтэй. Баянзүвх дүүргийн 12 дугаар хороо, Нарны зам 404 дугаар

1.9. Иргэн С.Энхболд /ЧД77082670/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2204033223 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, Пост 1 дүгээр гудамж, 1 тоот хувийн сууцны 000130654 дугаартай;

1.10. Иргэн С.Энхболд /ЧД77082670/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2204013067 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, Пост 1 дүгээр гудамж, 1 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000058285 дугаартай;

1.11. Иргэн Б.Бурмаа /ШЖ45011066/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2204055538 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Кристал таун /13311/, 803 дугаар байрны зоорийн давхар, №3-41 тоот авто зогсоолын 000282782 дугаартай;

1.12. Иргэн Т.Гэрэл /ШЖ85080660/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2204054527 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Кристал таун /13311/, 802 дугаар байрны зоорийн давхар, №2-54 тоот авто зогсоолын 000276389 дугаартай;

1.13. Иргэн Г.Болормаа /ЧЖ84081262/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2206046132 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, Үйлдвэр гудамж, 106/А дугаар байрны 40 тоот орон сууцны 000505521 дугаартай;

1.14. Иргэн Н.Бямбадаш /НЧ87082911/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2206025941 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Вива сити, 2/10 дугаар байрны 3-2 тоот орон сууцны 000267457 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/462

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн програмд мэдээлэл нь бүрэн тусгагдаагүй болон давхардсан улсын бүртгэлийн зөрчлийг шийдвэрлэх үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Болормаа  
Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга

Гишүүд: Б.Ганзориг  
Хяналтын газрын хяналтын улсын байцаагч  
Г.Санжаа  
Улсын бүртгэгч  
Ш.Доржбат  
Мэдээлэл, технологийн газрын Мэдээллийн сан,  
програм хангамжийн хэлтсийн програм зохиогч

Нарийн бичгийн дарга: Б.Лхагвасүрэн  
Улсын бүртгэгч

2. Тушаалын хавсралтад заагдсан зөрчлүүдийг шийдвэрлэж, дүнг 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Болормаа/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Д.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/463

Улаанбаатар хот


Семинарт оролцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Бүгд Найрамдах Франц Улсын Хөдөө аж ахуй, хүнс, ойн яамнаас ирүүлсэн урилгад тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Камбожийн Вант Улсын Кампот хотноо 2017 оны 5 дугаар сарын 22-ноос 26-ны өдрүүдэд зохион байгуулах "Газар зүйн заалтыг Азид нэвтрүүлэх нь" сургалтад тус газрын Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга Түвшинбаярын Хулан, Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын шинжээч Бадамсүрэнгийн Оргилмаа нарыг зохион байгуулагч талын санхүүжилтээр оролцуулсугай.

2. Тус семинарт идэвхтэй оролцож, Камбожийн Вант Улс болон оролцогч орнуудын газар зүйн заалтын эрх зүйн тогтолцоо, эрхийн хамгаалалтын системийн үйл ажиллагаатай танилцаж, үр дүнгийн талаар Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын хамт олонд сургалт, мэдээлэл хийхийг Э.Урангэрэл, Т.Хулан, Б.Оргилмаа нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/464


Улаанбаатар хот

Патент эзэмшигчийн эрх  
шилжүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Патентийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т заасныг тус тус үндэслэх ТУШААХ нь:


1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийн хүсэлтийг хянан үзээд эрх шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын улсын бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулж, эзэмшигчдэд Патент олгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын дарга С. Урангэрэлд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б. Бадамцэцэгт тус тус даалгасугай.

ДАРГА



Р. СОДХҮҮ

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын  
даргын 1/464 дугаар тушаалын хавсралт



**Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патентийн эрх шилжүүлэх жагсаалт**

№	Улсын бүртгэлийн дугаар	Эзэмшигчийн бүртгэгдсэн нэр, хаяг	Эзэмшичийн өөрчлөгдсөн нэр, хаяг
1	1986	Д.Цэцэгсүрэн	Мон пантокрин ХХК
2	3918	Qiqihar Railway Rolling Stock Co., Ltd.	CRRC Qiqihar Rolling Stock Co., Ltd.
3	3931	Ж.Эрдэнэбаатар, Б.Энхтуул, Ц.Лундаа	Мал эмнэлгийн хүрээлэн
4	3958	Qiqihar Railway Rolling Stock Co., Ltd.	CRRC Qiqihar Rolling Stock Co., Ltd.
5	4046	Qiqihar Railway Rolling Stock Co., Ltd.	CRRC Qiqihar Rolling Stock Co., Ltd.
6	4114	Oxford BioTherapeutics Ltd	Berlin-Chemie AG
7	4118	Ludowici Australia Pty Ltd	FLSmith A/S
8	3130	Sun Pharmaceutical Industries Limited	Western Express Highway, Goregaon
9	2295	Старсмит ХХК	Атар газар ХХК



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/465

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2202020854  
дугаарыг хүчингүй болгож, хувийн  
хэрэг бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэн П.Чинболор /УЧ88042407/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2202020854 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо, Согоотын 83 дугаар гудамж, 116е тоот хаягт байрлах 34 м.кв хувийн сууц нь Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт баригдсан Их тойруугийн 110/35/10 ктв-ын 7 дугаар хорооллын дэд станцаас 110/35/10 ктв-ын Радио телевизийн дэд станц хүртэлх 8.4 км цахилгаан дамжуулах агаарын шугамын трасст орж хувийн сууцыг нурааж газрыг чөлөөлсөн тул өмчлөгчийн гаргасан хүсэлт, Нийслэлийн өмчийн харилцааны газар болон иргэдийн хооронд байгуулсан "Иргэний өмчийн газрыг нөхөн олговортойгоор эргүүлэн авах тухай гэрээ", уг гэрээний протокол, Чингэлтэй дүүргийн Өмч газрын харилцааны албаны 2017 оны 02 дугаар сарын 22-ын өдрийн 08/836 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн эрхийн улсын бүртгэлийн Y-2202020854 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202020854 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000291020 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202020854 дугаартай хувийн хэрэг бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Х.Болорчулуунд зөвшөөрсүгэй

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Ганчимэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



P.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/466


Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалт, тус газрын даргын 2011 оны 630 дугаар тушаалаар батлагдсан "Улсын бүртгэгч бэлтгэх, улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах журам", "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 2014 оны 431, 1506 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оюуны өмч, улсын бүртгэлийн байгууллагын мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор "Улсын бүртгэгч бэлтгэх сургалт"-ыг энэ оны 05 дугаар сарын 22-ноос 05 дугаар сарын 26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Улсын бүртгэгч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг нэгдүгээр, сургалтын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалтын бэлтгэл ажлыг ханган зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Тамгын газрын дарга /Б.Бадамцэцэг/-д даалгасугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2017 оны 05 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“УЛСЫН БҮРТГЭГЧ БЭЛТГЭХ СУРГАЛТ”-ЫН ХӨТӨЛБӨР**  
/Ажлын байранд бэлтгэх сургалт/

2017 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

1. Сургалтын зорилго.

Энэхүү сургалтын зорилго нь улсын бүртгэгчээр томилогдохоор судлагдаж буй иргэнд улсын бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм журам, төрийн албан хаагчийн болон улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, иргэний болон эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр онол, дадлага, бүртгэлийн цахим системийн мэдлэг олгоход оршино.

2. Хөтөлбөр.

Сургалт 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн ажлын 5 өдрийн хугацаанд үргэлжлэх бөгөөд журамд заасны дагуу танхимын хичээл 16 цаг, ажлын байрны сургалт 24 цаг, бие даалт 8 цаг байна.

Сургалтыг дор дурдсан хөтөлбөрөөр явуулна. Үүнд:

д/д	Хичээлийн нэр, агуулга	Хугацаа	Сургалт явуулах газар, хэлтэс
Сургалтын 1 дэх өдөр / Танхимын сургалт/ 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдөр			
1	Бүртгэл	08.30 - 09.00	ХНСХ
2	Нээлт	09.00 – 09.10	Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг
3	Хуулийн этгээдийн бүртгэл, түүний төрөл, анхаарах асуудлууд Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн актууд	09.10 – 10.40	ХЭБГ-ын улсын ахлах бүртгэгч Я.Батцоож
4	Улсын бүртгэгч ба бүртгэлийн хяналт	10.40 – 11.15	ХГ-ын хяналтын улсын байцаагч Ш.Уртнасан
5	Иргэний баримтын архивын талаарх ойлголт	11.15 – 12.00	УБТАГ-ын ахлах мэргэжилтэн Д.Энхсаруул
6	Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн бүртгэлийн баримтын архивын талаарх ойлголт	12.00 – 12.30	УБТАГ-ын ахлах мэргэжилтэн Г.Хүчитбаатар
7	Завсарлага	12:30 - 13:30	
8	Захиргааны ерөнхий хууль	13.30 – 14.00	ЗЭГ-ын дарга Э.Мягмардорж
9	Төрийн албаны тухай хууль Улсын бүртгэлийн байгууллагын стандарт, улсын бүртгэлийн байгууллагын ажилтны ёс	14.00 – 15.00	ХНСХ-ийн мэргэжилтэн Т.Наранцэцэг

	зүй.		
10	Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн эрх зүйн зохицуулалт. Улсын бүртгэгчийн эрх, үүрэг, ажлын байранд тавигдах шаардлага.	15.00 – 16.00	ЭЗГХХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Үржинсүрэн
11	Хуулийн этгээдийн бүртгэлийн системийн талаар	16.00 – 16.30	МТГ-ын програмист Ш.Доржбат
12	Онлайн, офлайн, аффис системийн ашиглалт	16.30 – 17.00	МТГ-ын програмист С.Дэлгэрмөрөн
13	ePRS системийн талаар	17.00 – 17.30	МТГ-ын програмист Э.Мөнхжин
Сургалтын 2 дахь өдөр / Танхимын сургалт/ 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдөр			
14	Иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн актууд	9:00-09:30	ИБГ-ын улсын ахлах бүртгэгч Ц.Жавхлант
15	Иргэний улсын бүртгэл, түүний төрөл, анхаарах асуудлууд /Гэр бүлийн байдлын бүртгэл/	09:30-11:00	ИБГ-ын улсын ахлах бүртгэгч Ц.Жавхлант
16	Иргэний улсын бүртгэл, түүний төрөл, анхаарах асуудлууд / Шинэчилсэн бүртгэл, шилжилт хөдөлгөөн, гадаадад зорчих эрхийн бүртгэл /	11:00-12:30	ИБГ-ын улсын ахлах бүртгэгч Ц.Жавхлант
17	Завсарлага	12:30-13:30	
18	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн актууд	13.30-15:00	ЭХЭБ-ийн улсын ахлах бүртгэгч Ө.Өнөрлхам
19	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн төрөл, түүний онцлог, анхаарах асуудлууд	15:00-17:30	ЭХЭБ-ийн улсын ахлах бүртгэгч Ө.Өнөрлхам
Сургалтын 3 дахь өдөр / Танхимын болон ажлын байран дахь сургалт/ 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр			
20	Оюуны өмчийн эрхийн хамгаалалт	09.00-11.30	Зохиогчийн эрхийн газрын дарга Э.Мягмардорж
21	Албан хэрэг хөтлөлтийн стандарт	11.30-12.30	ХНСХ-ийн ахлах мэргэжилтэн Л.Өнөртуяа
22	Завсарлага	12:30-13:30	
23	Ажлын байрны сургалт /Бүртгэлийн анхан шатны нэгж дээрх дадлага/	13.30-14.30	ЧД-ийн 1 дүгээр хороо
24	Ажлын байран дахь сургалтыг томилогдох гэж буй ажлын байрны чиглэлээр дүүргийн бүртгэлийн хэлтэст ажлын дадлага олгох	14.30-17:30	Нийслэлийн дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс
Сургалтын 4 дэх өдөр / Ажлын байран дахь сургалт/ 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр			
25	Ажлын байран дахь сургалтыг томилогдох гэж буй ажлын байрны чиглэлээр дүүргийн	08:30-17:30	Нийслэлийн дүүргийн улсын

	бүртгэлийн хэлтэст ажлын дадлага олгох		бүртгэлийн хэлтэс
Сургалтын 5 дахь өдөр / Ажлын байран дахь сургалт/ 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр			
26	Ажлын байран дахь сургалтыг томилогдох гэж буй ажлын байрны чиглэлээр дүүргийн бүртгэлийн хэлтэст ажлын дадлага олгох	08:30-12:30	Нийслэлийн дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс
27	Тестийн шалгалт, сертификат гардуулах	14:00-17:00	ХНСХ

3. Тайлан, мэдээ

ХНСХ нь сургалтын бэлтгэл ажлыг ханган зохион байгуулж, үр дүнг ажлын 3 өдрийн дотор багтаан Тамгын газрын даргад танилцуулна.

--oOo--



Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2017 оны 116 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

### СУРГАЛТЫН ТӨСӨВ

д/д	Зардлын нэр, тайлбар	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Бичиг хэргийн зардал/ гэрчилгээ, дэвтэр бал, хавтас/	20	6000	120 000
2	Гарын авлага	20	4000	80 000
3	Гэрчилгээ	20	2500	50 000
4	Сургалтын үеэр хэрэглэх цэвэр ус	20*2 удаа*3 өдөр	120ш*450 төг	54 000
5	Сургагч багшийн урамшуулал	20 цаг	1 цагийн 20 000 төгрөг	400 000
6	Принтерийн хор /хар/	2	100 000	200 000
7	Принтерийн хор /цэнхэр/	1	90 000	96 000
	Нийт			1 000 000

Жич: Нэг хүний төлбөр 50 000 /тавин мянган/ төгрөг байна. Сургалтын төлбөрийг сургагч багшийн урамшуулал болон бусад холбогдох зардалд зарцуулна.

--oOo--



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар

A/467

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3.3, 38.3.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сонгуулийн бэлтгэл ажил, бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэл, аймгийн улсын бүртгэлийн байгууллагын албан хаагч, итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалтыг зохион байгуулах хөтөлбөрийг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтад зарцуулагдах 46 176 000 /Дөчин зургаан сая нэг зуун далан зургаан мянган/ төгрөгийг сонгуулийн зардлаас гаргахыг Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга /Ч.Хүрэлбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг нийслэл, аймгийн улсын бүртгэлийн газар, хэлтсийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга /Б.Бадамцэцэг/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



P.СОДХҮҮ



Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2017 оны 5 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

### ОРОН НУТАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

**ЗОРИЛГО:** Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх, батлагдан гарсан дүрэм, журмыг таниулах, сонгуулийн бэлтгэл ажлыг хангах, улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой анхаарах асуудлуудын талаар итгэмжлэгдсэн ажилтнууд болон улсын бүртгэлийн ажилтнуудад сургалт зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангахад оршино.

**СУРГАЛТЫН ХУГАЦАА:** Сургалт 2017 оны 5 дугаар сарын 27-ноос 30-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

Хөтөлбөр	
09.00 – 09.30	<b>Бүртгэл</b>
09.30 – 09.45	Нээлтийн ажиллагаа: Орон нутгийн удирдлага удирдан явуулна.
09.45 – 10.30	<b>Сэдэв:</b> Сонгуулийн тухай хууль <i>Хариуцах ажилтан: Аймаг, дүүргийн УБХ-ийн дарга нар</i>
10.30 – 11.15	<b>Сэдэв:</b> Сонгогчийн нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах, давхардлыг шалгах, сонгогч шилжих журам Сонгуулийн бэлтгэл ажилд анхаарах асуудал <i>Хариуцах ажилтан: Аймаг, дүүргийн УБХ-ийн улсын ахлах бүртгэгч нар</i>
11.15 – 11.30	<b>Завсарлага</b>
11.30 – 12.10	<b>Сэдэв:</b> Төрийн нууцын тухай <i>Хариуцах ажилтан: Аймаг, дүүргийн УБХ-ийн Хяналтын улсын байцаагч нар</i>
12.10 – 12.30	<b>Асуулт, хариулт</b>

**ТАЙЛАН, МЭДЭЭ :** Сургалтыг төвөөс хүргүүлсэн чиглэлийн дагуу аймаг, нийслэл дахь улсын бүртгэлийн хэлтсийн дарга, Хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч нар хариуцан зохион байгуулж, тайлан мэдээг ажлын 3 өдрийн дотор Хүний нөөц, сургалтын хэлтэст ирүүлнэ.

Оюуны амь улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2017 оны 11/28/17 тушаалын хоёрдугаар хавсралт

ОРОН НУТГИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Чиглэл	Итгэмжлэгдсэн ажилтны тоо	Нөөц ажилтны тоо	Нийт ажилтны тоо	Нэг хүнд ногдох зардал	Нийт зардлын дүн
1	Архангай	106	10	116	20,000	2,320,000
2	Баянхонгор	112	11	123	20,000	2,460,000
3	Баян-Өлгий	98	10	108	20,000	2,160,000
4	Булган	69	7	76	20,000	1,520,000
5	ГовьАлтай	82	8	90	20,000	1,800,000
6	Говьсүмбэр	12	3	15	20,000	300,000
8	Дархан-Уул	67	6	73	20,000	1,460,000
7	Дорноговь	70	7	77	20,000	1,540,000
9	Дорнод	79	8	87	20,000	1,740,000
10	Дундговь	48	6	54	20,000	1,080,000
12	Орхон	71	7	78	20,000	1,560,000
13	Завхан	117	12	129	20,000	2,580,000
14	Өвөрхангай	117	12	129	20,000	2,580,000
11	Өмнөговь	60	6	66	20,000	1,320,000
15	Ховд	98	10	108	20,000	2,160,000
16	Хөвсгөл	138	14	152	20,000	3,040,000
17	Хэнтий	94	9	103	20,000	2,060,000
18	Сүхбаатар	64	6	70	20,000	1,400,000
19	Сэлэнгэ	68	7	75	20,000	1,500,000
20	Төв	91	10	101	20,000	2,020,000
21	Увс	97	10	107	20,000	2,140,000
22	Нийслэл	796	152	948		7,436,000
	<b>Нийт дүн</b>	<b>2554</b>	<b>331</b>	<b>2,885</b>		<b>46,176,000</b>



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 1/468

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ч.Мандахын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хан-Уул дүүргийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Н.Батсүхийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Батсүх, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Энхболдод тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ







ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар

А/469

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Л.Одонгэрэлийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын хэсгийн улсын байцаагч С.Ганзоригийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Ганзоригт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Ариунжаргалд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 1/470

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Жугамт өргөө" ХХК, "Рокмон" ХХК, иргэн А.Оюунчимэг, А.Алтанхуяг нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Нагашыбайн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хан-уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Энхбаатарын Ганчимэг томилсугай.


2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Ганчимэг, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга С.Оюун-Эрдэнэд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/471


Улаанбаатар хот

Барааны тэмдэг эзэмшигчийн нэр,  
хаягийг өөрчлөх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Барааны тэмдэг эзэмшигчдийн хүсэлтийг хянан үзээд нэр, хаяг өөрчлөхийг зөвшөөрсүгэй.
2. Барааны тэмдгийн улсын бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулж, эзэмшигчдэд Гэрчилгээ олгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын дарга С. Урангэрэлд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б. Бадамцэцэгт тус тус даалгасугай.

ДАРГА



П. СОДХҮҮ

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын  
даргын ~~747~~ дугаар тушаалын хавсралт



**Барааны тэмдэг эзэмшигчийн нэр,  
хаягийг өөрчлөх, жагсаалт**

No.	Улсын бүртгэлийн дугаар	Эзэмшигчийн бүртгэгдсэн нэр, хаяг	Эзэмшигчийн өөрчлөгдсөн нэр, хаяг
1	6412	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
2	6413	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
3	6474	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
4	6476	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
5	6477	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
6	6486	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
7	6487	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
8	6489	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
9	6490	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
10	6551	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
11	6738	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
12	6879	Таван Богд Косметик ХХК	Таван Богд Интернэйшнл ХХК
13	12320	ALSTOM Technology Ltd	General Electric Technology GmbH
14	758	ORIENT TOKEI KABUSHIKI KAISHA	Seiko Epson Kabushiki Kaisha



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/472

Улаанбаатар хот

Зохиогчийн эрхийн  
гэрчилгээ олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 26.1.5 дахь заалт, зохиогчийн өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын бүртгэлийн 8660 ттот дугаартай гэрчилгээг олгосугай.

ДАРГА

P.СОДХҮҮ

Handwritten notes and a faint stamp at the bottom right of the page.



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/473

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ч.Пүрэвсүрэнгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хан-Уул дүүргийн иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Д.Бадамрагчааг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Бадамрагчаад, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Энхболдод тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/474

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2205018451 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Н.Болдбаатар /НВ77040317/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2205018451 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Төмөр зам гудамж 06 дугаар байр 1 тоот орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийг нурааж буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2205018451 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205018451 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000300020 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205018451 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Д.Бямбацогт-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ц.Билэгсүх нар тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/475

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2205018669  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Т.Энхболд /ХВ67090219/, Д.Даваажав /Ч344070107/, Т.Энхтуяа /Ч372090503/ нар нь өөрсдийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2205018669 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Төмөр зам гудамж 06 дугаар байр 2 тоот орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийг нурааж буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2205018669 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205018669 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 0096240 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205018669 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Д.Бямбацогт-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ц.Билэгсүх нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/476

Улаанбаатар хот

Зохиогчийн эрхийн  
гэрчилгээнд өөрчлөлт оруулж  
гэрчилгээ дахин олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 26.1.5 дахь заалт, зохиогчийн өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын бүртгэлийн 8218 дугаартай гэрчилгээний "Бүтээлийн нэр" гэсэн хэсэгт "Миний boy" гэснийг "Миний нууц" гэж өөрчилж олгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/477

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн  
Y-2205061847 дугаарыг хүчингүй болгож,  
Y-2205061837 дугаартай бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ж.Батбэлэг /ЧО57010511/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2205061847 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 18 дугаар хороо, 4 дүгээр хороолол, жалханц хутагт дамдинбазар гудамж 35бэ байр 83 тоот орон сууцыг иргэн Ж.Батбэлэг өөрийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-2205061837 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 18 дугаар хороо, 4 дүгээр хороолол жалханц хутагт дамдинбазар гудамж, 35 байр 82 тоот орон сууцтай нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-2205061847 дугаарыг хүчингүй болгож, Y-2205061837 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205061847, Y-2205061837 дугаартай бүртгэлийг нэгтгэж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 0000470567, 0000470560 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205061847 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Y-2205061837 дугаартай бүртгэлд шинээр гэрчилгээ олгохыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Ж.Үүрийнтуяад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ц.Билэгсүх нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/478

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2204019432,  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэн Ж.Алтанцэцэг /Ч370022469/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204019432 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Өлгийн 27 дугаар гудамжны 341Б тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрхээс татгалзсан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-2204019432 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204019432 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000391936 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204019432 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч С.Даваадоржид зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/479

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2204009859  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ж.Алтанцэцэг /Ч370022469/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204009859 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Өлгийн 27 дугаар гудамжны 340 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрхээс татгалзсан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-2204009859 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204009859 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000391934 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204009859 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч С.Даваадоржид зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/480

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2204041385  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ж.Алтанцэцэг /ЧЕ70022469/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204041385 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Өлгийн 27 дугаар гудамжны 342 Б тоот хаягт байрлах, хувийн сууцны зориулалттай барилгыг нураасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2204041385 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204041385 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000549139 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204041385 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч С.Даваадоржид зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2017 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/481

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2204001263  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ж.Алтанцэцэг /Ч370022469/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204001263 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Өлгийн 26 дугаар гудамжны 342 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрхээс татгалзсан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-2204001263 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204001263 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000391940 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204001263 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч С.Даваадоржид зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2017 оны 05 сарын 23 өдөр

Дугаар

А/482

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2204015761  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэн Ж.Алтанцэцэг /ЧЕ70022469/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204015761 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Өлгийн 26 дугаар гудамжны 342 тоот хаягт байрлах, хувийн сууцны зориулалттай барилгыг нураасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2204015761 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204015761 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000479167 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204015761 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч С.Даваадоржид зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/483

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2204005059  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ж.Алтанцэцэг /Ч370022469/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204005059 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Өлгийн 28 дугаар гудамжны 346 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрхээс татгалзсан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-2204005059 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204005059 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000419473 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204005059 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч С.Даваадоржид зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/484

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2204001188 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-1601000159 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000241732 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-1601000159 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч А.Туяад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар

А/521

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-1617002209  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн С.Энхтөр /ПЮ71022511/-ийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-1617002209 дугаарт бүртгэлтэй, Ховд аймгийн Жаргалант сумын Баатархайрхан баг, үйлдвэрийн районы 1 дүгээр гудамжны 16 тоот хаягт байрлах үйлчилгээний зориулалттай барилгыг нурааж, буулгасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-1617002209 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.
2. Эрхийн улсын бүртгэлийн Y-1617002209 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000203034 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.
3. Эрхийн улсын бүртгэлийн Y-1617002209 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Н.Жавзандуламд зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



P.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/522


Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-1617002206  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн С.Энхтөр /ПЮ71022511/-ийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-1617002209 дугаарт бүртгэлтэй, Ховд аймгийн Жаргалант сумын Баатархайрхан баг, үйлдвэрийн районы 1 дүгээр гудамжны 16 тоот хаягт байрлах үйлдвэрлэлийн зориулалттай барилгыг нурааж, буулгасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-1617002206 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.
2. Эрхийн улсын бүртгэлийн Y-1617002206 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000203053 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.
3. Эрхийн улсын бүртгэлийн Y-1617002206 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Н.Жавзандуламд зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар

А/523

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай:

1.1.иргэн Д.Даваадаш /М379081501/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-1307003507 дугаарт бүртгэлтэй, Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1дүгээр баг, Төмөр зам, 30 дугаар байрны 2-8-2 тоот хаягт байрлах, орон сууцны 000217498 дугаартай;

1.2.иргэн З.Цэцэгбадам /ВЖ88041807-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-0320004471 дугаарт бүртгэлтэй, Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 2 дугаар баг, 406 дүгээр гудамжны 10 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000234044 дугаартай;

1.3 иргэн М.Бадрал /ТЛ61071678/, Д.Алтанцэцэг /ТИ56031707/, Б.Цэндмаа /ВС96011007/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-0310000114 дугаарт бүртгэлтэй, Баянхонгор аймгийн Бууцагаан сумын 6 дугаар баг, Буянт Дарь эхийн 6 дугаар гудамж, 2 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000106725 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар

А/524

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2003008768  
дугаарыг хүчингүй болгож, Г-2003008690  
дугаартай бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Иргэн Ү.Базарсид /МОН76092312/ нь эрхийн улсын бүртгэлийн Г-2003008768 дугаарт бүртгэлтэй, Дархан-Уул аймгийн Дархан сум, 5 дугаар баг, Хүнсчид 1 дүгээр гудамжны 15а тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг, эрхийн улсын бүртгэлийн Г-2003008690 дугаарт бүртгэлтэй Дархан-Уул аймгийн Дархан сум, 5 дугаар баг, Хүнсчид 1 дүгээр гудамжны 15в тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын бүртгэлтэй нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2003008768 дугаарыг хүчингүй болгож, эрхийн улсын бүртгэлийн Г-2003008690 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2003008768 дугаарыг хүчингүй болгож Г-2003008690 дугаартай бүртгэлд нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000454865, 000430704 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2003008768 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Г-2003008690 дугаарт нэгтгэж бүртгэсэн эд хөрөнгөд шинээр гэрчилгээ олгохыг Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Ш.Цэндсүрэнд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Хувьзаяа нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар

1/525

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг хүчингүй болсонд тооцугай:

1.1. Иргэн Д.Оюун /ОЮ71121404/-ны өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2101001203 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 12 дугаар баг, Булаг 1 дүгээр гудамжны 99 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000046819 дугаартай;

1.2. Иргэн Г.Батцэдэв /ИС61100418/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2101003743 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 1 дүгээр баг, Зэст 1 дүгээр хороолол, 1 дүгээр байрны 57 тоот хаягт байрлах орон сууцны 0039668 дугаартай;

1.3. Иргэн Б.Болдбаатар /ТИ72031419/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2101004377 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 13 дугаар баг, Баянцагаан 6 дугаар гудамжны 30 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000046726 дугаартай;

1.4. Иргэн Д.Пүрэвсүрэн /АЭ78110210/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2101013757 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 17 дугаар баг, Эрдэнэ 24а гудамжны 1а тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000247520 дугаартай;

1.5. Иргэн Ш.Цацралтуяа /ГМ85100109/, Ш.Эрдэнэбаяр /ГМ88040513/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2101002037 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 9 дүгээр баг, Шанд 43 дугаар гудамжны 16 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000190063 дугаартай;

Боловруулсан  
Хүндэтгэсэн  
Хүндэтгэгч


1.6. Иргэн Ч.Удвал /ДВ65011604/, Д.Энхбаяр /ДВ63040131/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2101003426 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 5 дугаар баг, Бүрэнбүст 5 дугаар хороолол 15 дугаар байрны 66 тоот хаягт байрлах орон сууцны 001165186 дугаартай;

1.7. Иргэн З.Оюун-Эрдэнэ /ФА83061567/, Э.Үнэнбат /ФВ79052619/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2101006402 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 19 дүгээр баг, Их залуу 7 дугаар гудамжны 8 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000080685 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Э.Оюунбатад зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



P.СОДХҮҮ



УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/526

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-1723001584 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, улсын бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Д.Бат-Эрдэнэ /РБ70021930/, Н.Ариунбуян /РБ73111303/, Б.Золзаяа /РБ93071709/, Б.Дамдин /РБ99072619/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-1723001584 дугаарт бүртгэлтэй, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, 6 дугаар баг, 1 дүгээр гудамжны 19 тоот хаягт байрлах амины орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг нурааж буулгасан байх тул өмчлөгчдийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-1723001584 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-1723001584 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 0073986 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-1723001584 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Мягмарсүрэнд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Очирхуяг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ





УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/527

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-1705000180 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, улсын бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэн Ч.Мөнхбат /РД73073111/, Б.Цэвэлсоль /РД74022201/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-1705000180 дугаарт бүртгэлтэй, Хөвсгөл аймгийн Галт сум, 5 дугаар баг, 1-8-06 тоот хаягт байрлах хувийн сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө шатаж устсан байх тул өмчлөгчдийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-1705000180 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-1705000180 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000199204 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-1705000180 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Мягмарсүрэнд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Очирхуяг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/52В

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. С.Мөнгөнцэцэгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хан-уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Тэрсайханы Чимэгтэйг томилсугай.


2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.Чимэгтэй, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга С.Оюун-Эрдэнэд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/529

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. С.Мөнгөнзулын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хан-уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Энхбаатарын Ганчимэгийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Ганчимэг, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга С.Оюун-Эрдэнэд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/530

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Л.Бямбаноровын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр нэмж Эд хөрөнгийн бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Өлзийдаваагийн Өнөрлхамыг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Ө.Өнөрлхамд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн бүртгэлийн газрын дарга Д.Батболдод тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 7/531

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.10 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Оюуны өмч, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьсныг бүртгэх дэвтэр"-ийн загварыг хоёрдугаар хавсралтаар, "Зөрчлийн тэмдэглэл"-ийн загварыг гуравдугаар хавсралтаар, "Улсын байцаагчийн албан шаардлага, мэдэгдэл, акт, дүгнэлт"-ийн загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг бүртгэлийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын газрын дарга Ч.Эрдэнэчимэгт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан хяналтын улсын /ахлах/ байцаагчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлаж, мөрдүүлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2015 оны 1811 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

Оюун өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны 1154 дугаар тушаалын нэгдүгээр хэсрэлт

**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.  
Ерөнхий зүйл.**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь оюуны өмч, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх (цаашид "улсын бүртгэлийн"; "хяналт, шалгалт" гэх)-тэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хяналтын улсын байцаагч нь улсын бүртгэлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.

1.3. Хяналтын улсын байцаагч нь зөрчлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны зөрчигдсөн эрх болон ажил хэргийн нэр хүндийг сэргээх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор улсын бүртгэлийн үйл ажиллагаанд шалгалт хийнэ.

1.4. Хяналтын улсын байцаагч нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэлийн тухай хууль болон тэдгээрийг дагаж гарсан журмын дагуу улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийнэ. Мөн Зөрчил хянан шалгах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14, 6.20 дахь хэсэгт заасан харъяалалын дагуу иргэн, хуулийн этгээдийн үйлдсэн зөрчлийг хянан шийдвэрлэнэ.

**Хоёр. Хяналт, шалгалтын зарчим**

2.1. Хяналт, шалгалт нь дараах зарчимд үндэслэсэн байна:

- 2.1.1. хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх;
- 2.1.2. шалгуулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, хяналт, шалгалтын үйл ажиллагаа урьдаас төлөвлөсөн үр дүнд чиглэгдээгүй байх;
- 2.1.3. хяналт, шалгалт хийх эрх бүхий этгээд нь хөндлөнгийн аливаа нөлөөнд үл автан, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон өөрийн дотоод итгэлээр шийдвэр гаргах;
- 2.1.4. хяналт шалгалтын үр дүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны талаар эцэслэн шийдвэрлээгүй асуудлыг урьдчилан бусдад мэдээлэхгүй байх.

**Гурав. Хяналт, шалгалт хийх эрх**

3.1. Хяналт, шалгалт хийх чиг үүргийг дараах эрх бүхий этгээд хэрэгжүүлнэ:

- 3.1.1. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар ("цаашид ерөнхий газар" гэх)-ын Хяналтын асуудал хариуцсан нэгжийн хяналтын улсын /ахлах/ байцаагч;
- 3.1.2. аймаг, нийслэлд тухайн бүртгэлийн нэгжийн хяналтын улсын /ахлах/ байцаагч;
- 3.1.3. дүүрэгт тухайн дүүргийн хяналтын улсын байцаагч.

3.2. Аймаг, нийслэл, дүүрэг дэх хяналтын улсын /ахлах/ байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг ерөнхий газрын хяналтын асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

3.3. Энэ журмын 3.1.1, 3.1.2, 3.1.3 дахь заалт нь Улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу шалгалт хийхэд хамаарахгүй.

3.4. Шаардлагатай гэж үзвэл Улсын ерөнхий байцаагчийн шийдвэрийг үндэслэн улсын ахлах бүртгэгч болон нэгжийн хяналтын улсын байцаагч нарыг хяналт, шалгалтын үйл ажиллагаанд татан оролцуулж, туслалцуулж болно.

#### **Дөрөв. Хяналт, шалгалт хийх чиглэл**

4.1. Хяналт, шалгалтыг дараах чиглэлээр хийнэ:

- 4.1.1. иргэний улсын бүртгэл;
- 4.1.2. хуулийн этгээдийн улсын бүртгэл;
- 4.1.3. эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;
- 4.1.4. улсын бүртгэлийн архивын үйл ажиллагаа;
- 4.1.5. мэдээллийн технологийн үйл ажиллагаа;
- 4.1.6. оюуны эрхийн хамгаалалттай холбогдох үйл ажиллагаа.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ.**

#### **Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих**

##### **Тав. Хяналтын төрөл**

5.1. Хяналт нь дараах төрөлтэй байна:

- 5.1.1. өдөр тутмын хяналт;
- 5.1.2. түүвэрчилсэн хяналт /сар тутмын/

5.2. Хяналтын улсын /ахлах/ байцаагч бүртгэлийн хувийн хэрэг болон түүнтэй адилтгах архивын бусад эх нотлох баримтад үндэслэн хяналт тавина.

5.3. Улсын ерөнхий байцаагч болон ерөнхий газрын хяналтын нэгжийн дарга /цаашид "хяналтын нэгжийн дарга" гэх/ шаардлагатай тохиолдолд улсын бүртгэлийн ажиллагаанд биечлэн хяналт тавьж болно.

##### **Зургаа. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавих**

6.1. Иргэний улсын бүртгэлийн дараах үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавина:

- 6.1.1. иргэний үнэмлэхийн;
- 6.1.2. гадаадад зорчих эрхийн бүртгэл;

6.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дараах үйл ажиллагаанд өдөр тутмын

хяналтыг тавина:

6.2.1. Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын бүртгэл;

6.2.2. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулагчийн болон үүсгэн байгуулах баримт бичиг, түүнд орсон өөрчлөлтийн бүртгэл;

6.2.3. Улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгох бүртгэл;

6.2.4. Иргэн, хуулийн этгээдэд тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын хуудас дахин олгох;

6.3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дараах үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавина:

6.3.1. эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бүртгэл /анхны/;

6.3.2. барьцааны бүртгэл;

6.4. Энэ журмын 6.1-д заасан бүртгэлд аймаг, дүүрэг, ерөнхий газрын хяналтын нэгжийн хяналтын улсын байцаагч өдөр тутмын хяналт тавина.

6.5. Энэ журмын 6.2-т заасан бүртгэлд багануур дүүрэг, аймаг, ерөнхий газрын хяналтын нэгжийн хяналтын улсын /ахлах/ байцаагч өдөр тутмын хяналт тавина.

6.6. Энэ журмын 6.3-т заасан бүртгэлд аймаг, дүүрэг, ерөнхий газрын хяналтын нэгжийн хяналтын улсын /ахлах/ байцаагч өдөр тутмын хяналт тавина.

6.7. Хяналтын улсын /ахлах/ байцаагч улсын бүртгэгч бүртгэл хөтөлсөний дараа, иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн гэрчилгээг олгохоос өмнө, улсын бүртгэлийн хууль тогтоомжид заасан бүртгэл хөтлөх хугацааны дотор өдөр тутмын хяналтыг тавина.

6.8. Хяналтын улсын /ахлах/ байцаагч өдөрт тутмын хяналт тавихдаа журмын 14.4, 14.5 -д заасны дагуу улсын бүртгэлийн баримт бичиг болон цахим санд хянасан тухай тэмдэглэгээ хийнэ.

6.9. Журмын 6.8-д заасны дагуу тэмдэглэгээ хийсний дараа улсын бүртгэлийн гэрчилгээг иргэн, хуулийн этгээдэд олгоно.

6.10.Энэ журмын 3.1-д заасан эрх бүхий этгээд нь оюуны өмчийн эрхийн хамгаалалттай холбогдох үйл ажиллагаанд байнгын хяналт тавина.

#### **Долоо.Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд түүвэрчилсэн хяналт тавих**

7.1. Хяналтын улсын байцаагч нь энэ журмын 6.1, 6.2, 6.3-т зааснаас бусад дараах улсын бүртгэлийн үйл ажиллагаанд сар тутам түүвэрчилсэн хяналт тавина:

7.1.1.иргэний улсын 30-аас доошгүй бүртгэл;

7.1.2.эд хөрөнгийн эрхийн 30 -аас доошгүй бүртгэл;

7.1.3.хуулийн этгээдийн 30 -аас доошгүй бүртгэл;

7.1.4.улсын бүртгэлийн архивын 10 -аас доошгүй лавлагаа;

#### **Найм.Хяналт тавихад улсын бүртгэгч болон улсын бүртгэлийн ажилтны хамтын ажиллагаа**

8.1.Хяналтын улсын /ахлах/ байцаагч улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавихад улсын /ахлах/ бүртгэгч болон улсын бүртгэлийн бусад ажилтнууд нь холбогдох эх



нотлох баримт, жагсаалтыг гаргаж өгөх, хяналт, шалгалтын үйл ажиллагаанд ач холбогдол бүхий програм хангамжийн болон техник, технологийн асуудлуудыг шийдвэрлэж, шаардлагатай тохиолдолд тухайн бүртгэлийн талаар нэмэлт мэдээлэл, тайлбар өгөх зэргээр хамтран ажиллах үүрэгтэй.

8.2. Хяналтын улсын /ахлах/ байцаагч нь улсын /ахлах/ бүртгэгч болон улсын бүртгэлийн бусад ажилтнуудад хууль тогтоомжийн хүрээнд заавар, зөвлөгөө өгч ажиллана.

### **Ес. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих үед илэрсэн зөрчлийг шалгах**

9.1. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих явцад илэрсэн зөрчлийг энэ журмын Гуравдугаар бүлэгт заасан журмын дагуу шалгана.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд шалгалт хийх**

#### **10. Шалгалтын төрөл**

10.1. Шалгалт нь дараах төрөлтэй байна:

10.1.1. төлөвлөгөөт шалгалт;

10.1.2. төлөвлөгөөт бус шалгалт;

10.1.3. гүйцэтгэлийн шалгалт.

10.2. Төлөвлөгөөт шалгалтыг улсын бүртгэлийн байгууллагын жилийн болон стратеги төлөвлөгөөнд тусгасан төлөвлөгөөний дагуу хийнэ.

10.3. Төлөвлөгөөт бус шалгалтыг иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн мэдээ, нийтлэл, Улсын ерөнхий байцаагч болон хяналтын нэгжийн даргаас өгсөн чиглэл, бусад эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу тус тус хийнэ.

10.4. Гүйцэтгэлийн шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар илэрсэн зөрчил, тэдгээрийг арилгах, таслан зогсоох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар эрх бүхий этгээдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгах зорилгоор хийнэ.

10.5. Шалгалт нь хамрах хүрээгээрээ дараах төрөлтэй байна:

10.5.1. Иж бүрэн;

10.5.2. Хэсэгчилсэн.

10.6. Иж бүрэн шалгалт гэдэгт тухайн бүртгэлийн байгууллага /нэгж/-ын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааг бүхэлд нь хамарна.

10.7. Хэсэгчилсэн шалгалт гэдэгт тухайн бүртгэлийн байгууллага /нэгж/-ын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааны тодорхой хэсгийг хамарна.

#### **Арван нэг. Төлөвлөгөөт шалгалт хийх**

11.1. Төлөвлөгөөт шалгалтыг Улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу, тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэнэ.

11.2.Төлөвлөгөөт шалгалтыг бүрэлдэхүүнтэй хийх тохиолдолд шалгалтын багийн ахлагчийг Улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр томилох бөгөөд багийн ахлагч нь шалгалтын үр дүнг удирдлагын өмнө хариуцна.

11.3.Төлөвлөгөөт шалгалтыг хийх эрх бүхий этгээд нь дараах бэлтгэлийг хангасан байна:

11.3.1.тухайн шалгалтын объектын талаарх баримт бичиг болон урьд нь энэ талаар хийгдэж байсан шалгалтын материалыг урьдчилан судалсан байх;

11.3.2.тухайн шалгалтын объектоо холбоотой иргэдээс гаргасан өргөдөл, гомдол байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлтгүй урьдчилан танилцсан байх.

11.4.Шалгалтын үйл ажиллагаанд харшлахгүй бол төлөвлөгөөт шалгалт хийх байгууллагад шалгалтын удирдамжийг урьдчилан хүргүүлж, шалгалтыг эхлэх хугацаа, шаардлагатай баримт материалыг урьдчилан бэлтгэсэн байхыг мэдэгдэж болно.

11.5.Төлөвлөгөөт шалгалтыг тухайн байгууллагын удирдлагад шалгалтын зорилго, хамрах хүрээг танилцуулснаар эхэлнэ.

11.6.Удирдамжид заасан хугацаанд шалгалтыг гүйцэтгэж амжихгүй бол хугацааг Улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр сунгаж болно.

11.7.Төлөвлөгөөт шалгалт хийж буй хяналтын улсын /ахлах/ байцаагч нь шалгалтад хамрагдвал зохих баримт материалыг /тоо ширхэг, хуудасны дугаарыг нэг бүрчлэн/ холбогдох албан тушаалтнаар гарын үсэг зуруулан, хүлээн авч, шалгалт дууссаны дараа уг материалыг хүлээлгэн өгнө.

11.8.Төлөвлөгөөт шалгалтын үеэр шалгуулж байгаа байгууллага, албан тушаалтан, иргэнээс шалгалтын ажилд саад учруулах, шаардлагатай баримт өгөөгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх буюу эрх бүхий албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээний саналаа танилцуулах бөгөөд энэ тухай тэмдэглэл үйлдэж, зөрчлийн хувийн хэрэгт хавсаргана.

11.9.Төлөвлөгөөт шалгалтын явцад зөрчил илэрвэл энэ талаар дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэж, холбогдох ажилтнаас тайлбар гаргуулан авсан байна.

11.10.Төлөвлөгөөт шалгалтын үеэр илэрсэн зөрчлийг нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг төлөвлөгөөт шалгалт дууссаны дараа үргэлжлүүлэн шалгаж болно.

11.11.Шалгалтын явцад шалгалтын удирдамжид зааснаас өргөн хүрээнд шалгах шаардлага үүссэн тохиолдолд багийн ахлагчийн шийдвэрээр шалгалтын хүрээ болон чиглэлийг нэмэгдүүлж болно.

11.12.Журмын 11.11-д заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд шалгалтын багийн ахлагч Улсын ерөнхий байцаагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

#### **Арван хоёр.Төлөвлөгөөт бус шалгалт хийх**

12.1.Төлөвлөгөөт бус шалгалтыг иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн мэдээ, нийтлэл, Улсын ерөнхий байцаагч болон Хяналтын нэгжийн даргаас өгсөн чиглэл, бусад эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн хүрээнд хийнэ.

12.2.Төлөвлөгөөт бус шалгалтыг Хяналтын нэгжийн даргад мэдэгдсэнээр эхлүүлэх бөгөөд тусгайлан удирдамж батлуулах шаардлагагүй.

12.3.Төлөвлөгөөт бус шалгалтыг эхлүүлснээс хойш 14 хоногийн дотор хийж дуусгана.

12.4.Шаардлагатай тохиолдолд багийн ахлагчийн шийдвэрээр шалгалтын хүрээ болон чиглэлийг нэмэгдүүлж болно. Энэ тохиолдолд шалгалтын багийн ахлагч Улсын ерөнхий байцаагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

12.5.Төлөвлөгөөт бус шалгалтын явцад зөрчил илэрвэл энэ талаар дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэж, холбогдох ажилтнаас тайлбар гаргуулан авсан байна.

12.6.Төлөвлөгөөт бус шалгалтын үеэр шалгуулж байгаа байгууллага, албан тушаалтан, иргэнээс шалгалтын ажилд саад учруулах, шаардлагатай баримт материалыг гаргаж өгөхгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх буюу эрх бүхий албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээний саналаа танилцуулан, энэ тухай тэмдэглэл үйлдэж, зөрчлийн хувийн хэрэгт хавсаргана.

### **Арван гурав.Гүйцэтгэлийн шалгалт хийх**

13.1.Гүйцэтгэлийн шалгалтыг Улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн хүрээнд хийнэ.

13.2.Шалгалтын явцад удирдамжид зааснаас өргөн хүрээнд шалгах шаардлагатай тохиолдолд багийн ахлагчийн шийдвэрээр шалгалтын хүрээ болон чиглэлийг нэмэгдүүлж болно. Энэ тохиолдолд шалгалтын багийн ахлагч Улсын ерөнхий байцаагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

13.3.Гүйцэтгэлийн шалгалтыг хийх эрх бүхий этгээд нь дараах бэлтгэлийг хангасан байна:

13.3.1.тухайн шалгалтын объектын талаарх баримт бичиг болон урьд нь энэ талаар хийгдэж байсан шалгалтын материалыг урьдчилан судалсан байх;

13.3.2.тухайн шалгалтын объектоор холбоотой иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлттэй урьдчилсан танилцсан байх.

13.4.Шалгалтын үйл ажиллагаанд харшлахгүй бол гүйцэтгэлийн шалгалт хийх байгууллагад шалгалтын удирдамжийг урьдчилан хүргүүлж шалгалтыг эхлүүлэх хугацаа, шаардлагатай баримт материалыг урьдчилан бэлтгэсэн байхыг мэдэгдэж болно.

13.5.Гүйцэтгэлийн шалгалтыг тухайн байгууллагын удирдлагад шалгалтын зорилго, хамрах хүрээг танилцуулснаар эхэлнэ.

13.6.Удирдамжид заасан хугацаанд шалгалтыг гүйцэтгэж амжихгүй бол хугацааг Улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр сунгаж болно.

13.7.Гүйцэтгэлийн шалгалт хийж буй эрх бүхий этгээд нь шалгалтад хамрагдвал зохих баримт материалыг /тоо хэмжээ, хуудасны дугаарыг нэг бүрчлэн/ холбогдох албан тушаалтнаар гарын үсэг зуруулан, хүлээн авч шалгалт дууссаны дараа уг материалыг хүлээлгэн өгнө.

13.8.Гүйцэтгэлийн шалгалтын үеэр шалгуулж байгаа байгууллага, албан тушаалтан, иргэнээс шалгалтын ажилд саад учруулах, шаардлагатай баримт материалыг гаргаж өгөөгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх буюу эрх бүхий албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээний саналаа танилцуулан, энэ тухай тэмдэглэл үйлдэж, зөрчлийн хувийн хэрэгт хавсаргана.

13.9.Гүйцэтгэлийн шалгалтын явцад зөрчил илэрвэл энэ талаар дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэж, холбогдох ажилтнаас тайлбар гаргуулан авсан байна.

**Арван дөрөв. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлыг баримтжуулах, улсын  
бүртгэлийн баримт бичгийг хянан баталгаажуулах**

14.1. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчлийг боломжит бүхий л арга хэрэгслээр баримтжуулсан байна.

14.2. Шаардлагатай тохиолдолд тухайн нөхцөл байдал, зөрчлийг нягтлах зорилгоор шүүхийн шинжилгээний байгууллага болон холбогдох бусад газарт дүгнэлт гаргуулахаар хандаж болно.

14.3. Хяналтын улсын /ахлах/ байцаагч нь хяналт, шалгалтын явцад улсын бүртгэлийн баримт бичиг /бүртгэлийн дэвтэр, өргөдөл мэдүүлэг, холбогдох нотлох баримтууд/-т хянасан тухай тэмдэглэгээ хийнэ.

14.4. Журмын 14.3 дахь заалтыг хяналтын улсын /ахлах/ байцаагч хэрэгжүүлэхдээ баримт бичгийн баруун дээд өнцөгт хяналтын улсын/ахлах/ байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, гарын үсэг, албан тушаал, огноог бичиж хянан баталгаажуулна.

**Арван тав. Шалгалтын дүнг танилцуулах**

15.1. Шалгалтын дүнг тухайн шалгалтыг хийж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор Улсын ерөнхий байцаагч болон хяналтын нэгжийн даргад танилцуулна.

15.2. Шалгалтын хамрах хүрээг харгалзан энэ журмын 15.1-д заасан хугацааг Улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр сунгаж болно.

15.3. Шалгалтын дүнг энэ журмын 16.1.1-д заасан илтгэх хуудсаар танилцуулна.

15.4. Шалгалтын илтгэх хуудсанд холбогдох баримт, нотолгоог хавсаргасан байна.

15.5. Улсын ерөнхий байцаагч шаардлагатай гэж үзсэн бол шалгалтын дүнг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж болно.

15.6. Шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл түүнийг шалгуулахаар холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

15.7. Шаардлагатай гэж үзвэл шалгалттай холбоотойгоор холбогдох этгээдэд энэ журмын 18, 19-т заасан улсын байцаагчийн албан шаардлага, мэдэгдэл хүргүүлж болно.

15.8. Шалгалтаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрөхгүй бол улсын /ахлах/ бүртгэгч болон холбогдох бусад албан хаагч ерөнхий газрын хяналтын нэгжийн дарга болон ерөнхий байцаагчид тайлбар, гомдлоо бичгээр гаргаж болно.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

**Хяналт, шалгалтын үед үйлдэх баримт бичиг**

**Арван зургаа. Хяналт, шалгалтын үед үйлдэх баримт бичиг**

16.1. Хяналтын улсын /ахлах/ байцаагч нь хяналт, шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах баримт бичгийг үйлдэнэ:

16.1.1. илтгэх хуудас;

16.1.2. улсын байцаагчийн албан шаардлага;

16.1.3.улсын байцаагчийн мэдэгдэл;

16.1.4.зөрчлийн тухай тэмдэглэл;

16.1.5.улсын байцаагчийн акт;

16.1.6.улсын байцаагчийн дүгнэлт.

16.2.Энэ журмын 16.1.2, 16.1.3, 16.1.5, 16.1.6-д заасан баримт бичгийг хэвлэмэл хуудсан дээр үйлдэнэ.

16.3.Энэ журмын 16.1-д заасан баримт бичиг нь эрх бүхий этгээд гарын үсгээ зурж, улсын /ахлах/ байцаагчийн тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

#### **Арван долоо. Илтгэх хуудас**

17.1.Илтгэх хуудсыг шалгалтын үр дүнг удирдагад танилцуулахад үйлдэнэ.

17.2.Илтгэх хуудсанд дараах зүйлийг тусгана:

17.2.1.шалгалтын зорилго, хугацаа;

17.2.2.шалгалт хийсэн эрх бүхий этгээдийн албан тушаал, эцгийн нэр, нэр;

17.2.3.шалгуулсан байгууллага, албан тушаалтны нэр;

17.2.4.шалгалтын хамрах хүрээ;

17.2.5.шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал;

17.2.6. Мэргэжлийн заавар, зөвлөгөө өгсөн байдал;

17.2.6.цаашид авах арга хэмжээний санал.

17.3.Илтгэх хуудсыг Хяналтын нэгжийн дарга, Улсын ерөнхий байцаагч нар гарын үсэг зурж, Улсын /ерөнхий, ахлах/ байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулна.

17.4.Хяналтын улсын /ахлах/ байцаагч нь илтгэх хуудсанд дурдсан цаашид авах арга хэмжээний талаарх тодорхой саналын төслийг боловсруулж, эрх бүхий албан тушаалтанд танилцуулна.

#### **Арван найм. Улсын байцаагчийн албан шаардлага**

18.1.Улсын байцаагчийн албан шаардлагыг шалгалтаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцлийг арилгахаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардах тохиолдолд үйлдэнэ.

18.2.Албан шаардлага нь хугацаатай байх бөгөөд албан шаардлагыг хүлээн авагч нь уг хугацааны дотор хариу мэдэгдэх үүрэгтэй.

18.3.Албан шаардлагад дараахь зүйлийг тусгана:

18.3.1.хүлээн авагч байгууллага, албан тушаалтны нэр;

18.3.2.хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаарх мэдээлэл;

18.3.3.илэрсэн зөрчлийг арилгахтай холбогдсон үүрэг даалгавар;

18.3.4. үүрэг даалгаварыг биелүүлэх хугацаа;

18.3.5. шаардлагын хариуг заасан хугацаанд биелүүлээгүйгээс үүсэх хариуцлага

18.3.6. албан шаардлага үйлдсэн улсын /ахлах/ байцаагчийн эцэг /эх/-ийн нэр, нэр, албан тушаал;

18.3.7. албан шаардлага хүлээн авсан албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, нэр, гарын үсэг.

#### **Арван ес. Улсын байцаагчийн мэдэгдэл**

19.1. Улсын байцаагчийн мэдэгдлийг шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн удирдлагад шалгалтын үеэр илэрсэн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар чиглэл хүргүүлэх тохиолдолд үйлдэнэ.

19.2. Улсын байцаагчийн мэдэгдэлд дараах зүйлийг тусгана:

19.2.1. хүлээн авагч байгууллага, албан тушаалтны нэр;

19.2.2. хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаарх мэдээлэл;

19.2.3. зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцлийг арилгахтай холбогдсон үүрэг даалгавар;

19.2.4. мэдэгдэл үйлдсэн улсын /ахлах/ байцаагчийн эцгийн нэр, нэр, албан тушаал, гарын үсэг.

#### **Хорь. Зөрчлийн тухай тэмдэглэл**

20.1. Зөрчлийн тухай тэмдэглэлийг зөрчил гарсан нөхцөл байдлыг баримтжуулахад үйлдэнэ.

20.2. Зөрчлийн тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

20.2.1. зөрчил гарсан он, сар, өдөр, цаг;

20.2.2. зөрчил гаргасан этгээдийн эцгийн нэр, нэр, хаяг эрхэлсэн ажил;

20.2.3. зөрчлийн байдал, учруулсан хохирол, өмнө нь захиргааны зөрчил гаргасан эсэх;

20.2.4. зөрчилд хамаарах хууль тогтоомж, стандартын заалтын дагуу авах арга хэмжээ;

20.3. Зөрчлийн тэмдэглэлд зөрчил гаргасан этгээдийн тайлбарыг хавсаргана.

20.4. Зөрчлийн тэмдэглэлд зөрчил гаргасан этгээдийн гарын үсгийг зуруулах бөгөөд ийнхүү зурахаас татгалзсан бол татгалзах болсон шалтгааныг бичүүлсэн байна.

#### **Хорин нэг. Улсын байцаагчийн акт**

21.1. Улсын байцаагчийн актыг хууль бусаар олсон орлогыг төсөвт оруулах, зөрчил дутагдлыг тогтоон нөхөн төлбөр ногдуулах, зөрчилтэй баримт бичгийг хураан авахад үйлдэнэ.

21.2. Улсын байцаагчийн актад дараах зүйлийг тусгана:

21.2.1. зөрчил гаргасан этгээдийн эцэг /эх/-ийн нэр, нэр, албан тушаал;

21.2.2. шалтгалтаар илэрсэн зөрчлийн тодорхой утга, агуулга;

21.2.3. баримт бичгийг хураан авсан үндэслэл;

21.2.4. төлүүлэхээр шийдвэрлэсэн төлбөрийн дүн, торгууль барагдуулах хугацаа;

21.2.5. төлбөрийг хугацаанд нь барагдуулж, илэрсэн зөрчлийг арилгаагүй тохиолдолд зохих хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх;

21.2.6. акт үйлдсэн улсын /ахлах/ байцаагчийн эцэг /эх/-ийн нэр, нэр, албан тушаал;

21.2.7. актыг хүлээн авсан эрх бүхий албан тушаалтны эцгийн нэр, нэр, албан тушаал.

#### **Хорин хоёр. Улсын байцаагчийн дүгнэлт**

22.1. Улсын байцаагчийн дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлт, иргэн, хуулийн этгээдийн гомдлын дагуу улсын бүртгэлтэй холбоотой тодорхой нөхцөл байдлыг тогтооход үйлдэнэ.

22.2. Улсын байцаагчийн дүгнэлтэд дараах зүйлийг тусгана:

22.2.1. дүгнэлт гаргах хууль зүйн үндэслэл;

22.2.2. нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий нотлох баримтыг үнэлэх;

22.2.3. дүгнэлтээр тогтоогдсон нөхцөл байдал;

22.2.4. цаашид авах арга хэмжээ;

22.2.5. дүгнэлт гаргасан улсын /ахлах/ байцаагчийн эцгийн нэр, нэр, албан тушаал.

22.3. Улсын байцаагчийн үйлдсэн дүгнэлтийг улсын бүртгэлийн цахим сангийн дүгнэлт бүртгэлийн санд хөтөлнө.

22.4. Улсын байцаагчийн дүгнэлт нь нэгдсэн дугаартай байх бөгөөд дугаарлалт нь мэдээллийн нэгдсэн сангаас олгогдоно.

22.5. Улсын бүртгэлийн цахим санд бүртгэсэн аймаг, нийслэл, дүүрэг, ерөнхий газрын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлтийг Хяналтын нэгжийн даргын баталсан хуваарийн дагуу Хяналтын нэгжийн хяналтын улсын /ахлах/ байцаагч ажлын 3 хоногийн дотор хянан баталгаажуулна.

#### **Хорин гурав. Хяналт шалгалтын үед үйлдэх баримт бичигт тавигдах шаардлага**

23.1. Хяналт шалгалтын үед үйлдэх баримт бичиг нь албан хэрэг хөтлөлтийн журам, зааварт нийцсэн, бичиг хэргийн стандартын шаардлага хангасан байна.

23.2. Хяналт шалгалтын үед үйлдэх баримт бичиг энэ журмын 23.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

23.2.1. асуудлын ач холбогдол уялдаа холбоог нарийвчлан тогтоож, товч тодорхой бичсэн байх;

23.2.2. заалт бүр нь түүний утга санааг бүрэн илэрхийлсэн байх;

23.2.3. заалтын дэс дарааллыг тогтоохдоо асуудлын ач холбогдол, агуулгын уялдааг харгалзсан байх;

23.2.4. зөвхөн нийтээр хэвшиж тогтсон төрийн албан ёсны бичгийн болон хууль зүйн нэр томъёо, үг хэллэг, стандартаар тогтоосон нэр томъёог хэрэглэх;

23.2.5. шаардлагатай бол хүчин төгөлдөр болох хугацааг заасан байх;

23.2.6. улсын /ахлах/ байцаагчийн тэмдгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу тэгш тод гаргацтай дарсан байх;

23.3. Хяналт, шалгалтын үед үйлдэх баримт бичигт цохолт, нэмэлт бичилт, засвар хийхийг хориглоно.

#### **ТАВДУГААР БҮЛЭГ.**

##### **Хорин дөрөв. Бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах**

24.1. Хяналтын улсын /ахлах/ байцаагч нь улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өдөр тутмын болон түүвэрчилсэн хяналт тавьсан талаар бүртгэлийн дэвтэр хөтөлж, зөрчил илэрсэн тохиолдолд илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтөлнө.

24.2. Энэ журмын 24.1-д заасан илэрсэн зөрчлийн талаар зөрчлийн тэмдэглэлийг 2 хувь хөтлөх бөгөөд нэг хувийг ерөнхий газрын Хяналтын нэгжид, шаардлагатай тохиолдолд холбогдох нотлох баримтуудыг хавсарган хүргүүлнэ.

24.3. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьсан талаар нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээ тайланг нэгтгэж, тайлагнах чиг үүргийг хяналтын нэгж хэрэгжүүлнэ.

